



БАРИЛГА,  
ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН  
ТУШААЛ

2017 оны 3 сарын 27 өдөр

Дугаар 57

Улаанбаатар хот

Журам, бүрэлдэхүүн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын 2016 оны 136 дугаар тогтоолыг үндэслэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн 2017 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 1 дүгээр зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбарын үйл ажиллагааг зохицуулах, хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий “Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн ажиллах журам”-ыг 1 дүгээр, бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Журмыг мөрдөж ажиллахыг “Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөл”-д даалгасугай.

САЙД

*G. Munkhbayar*

Г.МӨНХБАЯР



Барилга, хот байгуулалтын сайдын  
2017 оны 5-р дугаар сарын 17-ны  
өдрийн 54-р дугаар тушаалын  
1 дүгээр хавсралт



**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ  
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ  
ОРОН ТООНЫ БУС ДЭД ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ**

**Нэг. Ерөнхий зүйл**

1.1. Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөл (цаашид “зөвлөл” гэх)-ийн үйл ажиллагаа нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай НҮБ-ын конвенци, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд тэгш оролцох эрхийг хангаж хэрэгжүүлэх, хамгаалахтай холбогдсон үйл ажиллагааг салбарын зохицуулалтаар хангаж, дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.

1.2. Зөвлөл нь үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээ болон энэ журмыг удирдлага болгон ажиллана.

**Хоёр. Зөвлөлийн бүрэлдэхүүн, зохион байгуулалт**

2.1. Зөвлөл нь дарга, дэд дарга, гишүүд, нарийн бичгийн даргаас бүрдэнэ.

2.2. Зөвлөлийн дарга нь Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга, дэд дарга нь яамны газрын дарга байна.

2.3. Нарийн бичгийн дарга нь яамны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал хариуцсан мэргэжилтэн байна.

2.4. Зөвлөл нь холбогдох төрийн байгууллага, мэргэжлийн байгууллага, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын төлөөллөөс бүрдэнэ.

2.5. Зөвлөл нь яамны албан бичгийн хэвлэмэл хуудас болон тэмдгийг хэрэглэнэ.

2.6. Зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг төсөвт жил бүр тусгах замаар санхүүжүүлнэ.

2.7. Зөвлөл нь жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж ажиллах ба яамны зохион байгуулалтын бүтцийн нэгж, ажилтнууд чиг үүргийн дагуу төлөвлөгөөнд тусгагдсан ажил, арга хэмжээг хийж гүйцэтгэнэ. Төлөвлөгөөг зөвлөлийн дарга батална.

2.8. Зөвлөл нь тухайн онд хэрэгжүүлсэн ажлын тайланг хагас жил, жилээр гаргаж тухайн оны 7, дараа жилийн 1 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн хэлтэст хүргүүлнэ.

## Гурав. Зөвлөлийн хуралдаан

3.1. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Зөвлөл жилд 2-оос доошгүй удаа хуралдана. Зөвлөлийн ээлжит бус хуралдааныг зөвлөлийн даргын болон гишүүдийн олонхийн санаачилгаар зарлан хуралдуулж болно.

3.2. Зөвлөлийн гишүүдийн олонх нь хүрэлцэн ирснээр хуралдааныг хүчинтэйд тооцно.

3.3. Зөвлөлийн даргын эзгүйд хуралдааныг дэд дарга даргална.

3.4. Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудал, холбогдох материалыг дэд даргаас танилцуулсны үндсэн дээр дарга хуралдааны тов, хэлэлцэх асуудлыг тогтооно. Хэлэлцүүлэх асуудлаар шийдвэр гаргахаар бол тушаалын төслийг хавсаргасан байна.

3.5. Зөвлөлийн хуралдаан болохоос ажлын 3-аас доошгүй хоногийн өмнө хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, холбогдох материалыг гишүүдэд хүргүүлнэ.

3.6. Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Хуралдааны материалыг хүлээн авсан боловч хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралд оролцоогүй гишүүний бичгээр ирүүлсэн саналыг хүчинтэйд тооцно. Гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд асуудлыг хуралдаан даргалагчийн саналаар шийдвэрлэнэ.

3.7. Зөвлөлийн гишүүн нь салбарын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар санал боловсруулж, хуралдаанаар хэлэлцүүлж болно. Гишүүн нь зөвлөлөөс даалгасан үүргийг биелүүлж, түүний явц, дүнг хуралдаанд танилцуулна.

3.8. Зөвлөлийн нарийн бичгийн дарга хуралдааны явцын тухай тэмдэглэл хөтөлнө. Тэмдэглэлд дарга, нарийн бичгийн дарга нар гарын үсэг зурж баталгаажуулна.

\_\_\_\_\_ оОо \_\_\_\_\_